

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.10.01-10.05

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн Dow Jones болон S&P 500 индексүүд уналттай хаагдсан бол Nasdaq индекс өсөлттэй хаагдлаа. АНУ-ын Ираны эсрэг авч буй хориг арга хэмжээ энэ оны 11-р сараас эхлэн хэрэгжихтэй холбоотойгоор газрын тосны үнэ нэмэгдэж, S&P 500 индексийн сагсанд багтдаг эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш өсчээ. Мөн урт хугацааны бондын хүүний түвшин нэмэгдэж, санхүүгийн салбарын компаниудын ханш өсөлт үзүүлэв.

Хамгийн том тансаг хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компани болох "Amazon.com" ажилчдынхаа цагийн цалингийн хэмжээг 15 ам.доллараар нэмсэн нь тус компанийн хувьцааны ханш унах гол шалтгаан болжээ.

АНУ-ын хөдөлмөрийн яамны мэдээлснээр 9-р сард нийт 134,000 ажлын байр нэмэгдсэн нь энэ оны хамгийн бага үзүүлэлт боловч ажилгүйдлийн түвшин 3.7% буюу сүүлийн 50 орчим жилд үзэгдээгүй доод хэмжээнд хүрчээ.

Европ: АНУ-ын бондын өгөөж нэмэгдэж, Итали улсын Засгийн газрын төсвийн зарлагыг тойрсон асуудлаас үүдэн Европын компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна.

Италийн Засгийн газар 2019 оны төсвийн бодлогоо тодорхойлж, 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын өгөөж нэмэгдэн, 3.45 хувь хүрчээ. Тус улсын Засгийн газар 2019 оны төсвийн алдагдлаа таамаг хэмжээнээс ихээр буюу 2.4% байхаар баталсан юм. Энэ нь Европын Холбооноос тус улсад тавьсан шаардлагыг хангахгүй байгаа ба Италийн зээлжих зэрэглэл унах эрсдэлийг үүсгэсэн. Үүний үр дүнд тус улсын банкуудын хувьцааны ханш унасан байна.

Япон: Японы компаниудын хувьцааны ханш өсөлттэй хаагдлаа. Иенийн ханш ам.долларын эсрэг чангарч, 113.89 болов.

Ирэх онд Япон улс хэрэглээний татварын хэмжээг нэмж, 8%-аас 10% болгож байгаатай холбогдуулан тус улсын эдийн засгийн өсөлт удааших магадлалтай талаар Олон улсын валютын сан мэдээллээ. Мөн худалдааны маргаан болоод геополитикийн нөхцөл байдал иенийн ханш чангарахад нөлөөлж магадгүй ажээ. Японы хүн амын тоо буурч байгаатай холбоотойгоор тус улс хэрэглээний татварын хэмжээг хамгийн багадаа 15 хувь байхаар өсгөх хэрэгтэй гэж ОУВС үзэж байна. Японы хүн ам ирэх 40 жилийн хугацаанд 25%-аар буурна гэсэн урьдчилсан таамаг гарчээ.

БНХАУ: БНХАУ-ын Засгийн газар АНУ-ын татварын арга хэмжээг зөөллөх зорилгоор гаалийн татварын хувь хэмжээгээ буулгаж байгаа ажээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,399.08	0.34% ▲
Dow Jones	АНУ	26,447.05	-1.07% ▼
S&P 500	АНУ	2,885.57	-0.54% ▼
Nasdaq	АНУ	7,788.45	0.74% ▲
S&P/TSX	Канад	15,946.17	-0.93% ▼
FTSE 100	Их Британи	7,318.54	0.27% ▲
S&P/ASX 200	Австрали	6,185.50	-0.36% ▼
Nikkei 225	Япон	23,783.72	1.05% ▲
Hang Seng	Хонг Конг	26,572.57	-0.59% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	109.40
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	97.15
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	96.21
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	112.87
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.39
TDBM' 2020	USD	9.3%	105.86

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.277	0.02 ▲
Libor 3M	2.408	0.01 ▲
Libor 6M	2.623	0.02 ▲
Libor 1YR	2.958	0.04 ▲
US 6M Bond	2.405	0.05 ▲
US 2YR Bond	2.885	0.06 ▲
US 3YR Bond	2.982	0.09 ▲
US 5YR Bond	3.069	0.11 ▲
US 10YR Bond	3.233	0.16 ▲

Валютын ханш /төг/

Валют	2018.10.05	Өөрчлөлт
USD	2,567.15	0.59% ▲
CNY	373.74	0.78% ▲
EUR	2,953.76	-0.39% ▼
RUB	38.54	-0.93% ▼
KRW	2.27	-1.30% ▼
JPY	22.55	0.22% ▲
CAD	1,984.65	1.19% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,196.19	0.48% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	14.46	-1.23% ▼
Зэс	USD/lb.	274.35	-2.09% ▼
Нүүрс	USD/MT	114.32	-0.07% ▼
WTI газрын тос	USD/bbl.	73.72	0.31% ▲
Brent газрын тос	USD/bbl.	83.28	0.26% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	3.18	5.30% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. VIII	6.00%
Бодлогын хүү	2018. VIII	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. VIII	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. VIII	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. VIII	5.10%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. VIII	17.60%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. VIII	10.60%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 40 компанийн 2,775.5 сая төгрөгийн 11,843,142 ширхэг хувьцаа арилжигдав.


“Ард даатгал” /AIC/ компанийн хувьцаа 28.50%-аар буюу хамгийн ихээр өсч 899.48 төгрөгт хүрч хаагдсан бол “Их барилга” /IBA/ компанийн хувьцаа 14.49%-аар буурч 2,950 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 154 ширхэг үнэт цаас 15.5 сая төгрөгөөр арилжаалагджээ.


10-р сарын 5-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,406.0 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,399.08 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.34%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	2,791.0
Зах зээлийн үнэлгээ	2,405,993.0

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,399.08	0.34% ▲
MSE I индекс	9,792.76	2.19% ▲
MSE II индекс	9,170.47	3.22% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Говь	21,458	690,805,580
Ард даатгал	785,719	637,847,277
Айтүүлс	4,119,523	494,372,782
ЛэндМН ББСБ	6,252,971	399,853,674
АПУ	242,528	139,665,852

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Ард даатгал	899.48	28.50% ▲
Женко тур бюро	75.00	25.00% ▲
Шивээ овоо	2,000.00	17.65% ▲
Багануур	1,552.00	14.96% ▲
Атар-Өргөө	80,000.00	14.29% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Их барилга	2,950.00	-14.49% ▼
Гутал	19,500.00	-9.30% ▼
Тахь-Ко	12,000.00	-7.69% ▼
УБ-БҮК	337.00	-3.71% ▼
Баянгол зочид буудал	29,000.00	-3.33% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Стандарт инвестмент	1,688,513,366
Мирэ Эссет Секьюритис Монгол	763,785,984
Ард секьюритиз	672,203,422
Бумбат-Алтай	409,147,431
БиДиСек	408,461,972

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	571.94	608,648
Таван толгой	7,715.00	406,312
Говь	33,080.00	258,061
МИК	10,970.00	227,181
Сүү	226.04	77,758

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-04/07/19-A0266-14.82	153	15,76,500	100,500	100,500	104	14.820%
2	ZGEB-BD-06/06/19-A0254-15.49	1	103,000	103,000	103,000	104	15.490%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.01-2018.11.30
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дютти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Миллениум CSD системийг амралтын өдрүүдэд ажиллуулахаар боллоо

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн иргэдэд эзэмшүүлсэн хувьцааг дотоод, гадаадын хөрөнгийн биржээр арилжаалж эхлэх тухай төр, засгийн тогтоол, шийдвэрүүдтэй холбоотойгоор иргэдийн үнэт цаасны данс нээлгэх үйл ажиллагаа сүүлийн үед идэвхжиж байгаа билээ. Тухайлбал, 2018 оны эхний хагас жилд сард дунджаар 5000-6000 данс нээгдэж байсан бол 8-р сард 8902, 9-р сард 24682 данс тус тус нээгдсэн үзүүлэлттэй байна.

Үүнтэй холбогдуулан, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/109 тоот тушаалын дагуу үнэт цаасны дансны бүртгэлийг гүйцэтгэх Миллениум CSD системийг 2018 оны 11-р сарыг дуустал амралтын өдрүүдэд ажиллуулахаар боллоо.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



I сараас хойш Засгийн газрын бондууд 4-6 хувиар уналаа

Одоогоор олон улсын зах зээлд Монгол Улсын Засгийн газрын дөрвөн бонд арилжигдаж байна. Энэ он гарснаас хойш бондуудын ханш 4-6 хувиар унаад байгаа аж. Хэдий тийм боловч анх гаргасан үнээсээ буугаагүй байна.

Ерөнхийдөө өнгөрсөн онд Олон Улсын Валютын Сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн I, II шатны үнэлгээний дараа үзүүлсэн өсөлтөө эргүүлэн алдсан хөдөлгөөн ажиглагдаж байна. Тухайлбал, өнгөрсөн онд гаргасан 5.625 хувийн хүүтэй “Гэрэгэ” бондын ханш он гарснаас хойш дөрвөн хувиар унаж, 97.15 ам.долларт хүрчээ.

Эдийн засгийн хүнд үед эргэн барагдуулах хугацаа нь ойртож байсан “Чингис”, “Дим Сам” бондыг санхүүжүүлэх үндсэн зорилгоор “Гэрэгэ” бондыг гаргаж байсан бөгөөд төлөвлөгөөний дагуу таван жилийн хугацаатай “Чингис” бонд болон юаниар нэрлэгдсэн “Дим Сам” бондын өрийг энэ онд бүрэн барагдуулсан юм.

Харин хамгийн ойрын хугацаанд өрийг барагдуулах хуваарьтай, хамгийн өндөр хүүтэй “Мазаалай” бондын үнэлгээ ч бас 1-р сараас хойш дөрвөн хувиар доошилсон байна. 2016 онд Засгийн газрын төсвийн зарцуулалт нэмэгдэж, түүхий эдийн үнэ унаснаар Монгол Улсын төсөв санхүүгийн байдал хүндэрч, улмаар 2016 оны гуравдугаар сард таван жилийн хугацаатай 500 сая ам.долларын “Мазаалай” бондыг 10.875 хувийн хүүтэй гаргахад хүрсэн юм. “Хуралдай”, “Чингис” бондын хувьд ч мөн ханш нь доошилсон үзүүлэлттэй байна.

Монгол Улсын бондуудын гол эзэмшигчдэд “JPMorgan Chase”, “UBS”, “Blackrock” зэрэг тэргүүлэх хөрөнгө оруулагчид багтаж байна. “Bloomberg”-ийн шинжээчдийн судалгаагаар хөрөнгө оруулагчид харьцангуй өндөр хүүтэй хөгжиж буй орны бонд сонирхох нь нэмэгджээ. Ялангуяа донорын санхүүжилт өндөр, Олон Улсын Валютын Сангийн хөтөлбөр хэрэгжиж буй эрсдэлийн жийргэвчтэй орны бондуудыг илүү сонирхох болсон байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

Хөрөнгийн захад IX сард өмнөх сараас 6 дахин их үнэт цаас арилжлаа

“9-р сард дотоодын хөрөнгийн захад 20 гаруй тэрбум төгрөгийн үнэт цаас арилжсан байна. Өөрөөр хэлбэл, 8-р сарынхаас зургаа дахин их хэмжээний арилжаа явагдахад хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа 16.5 тэрбум төгрөгт хүрсэн нь гол нөлөөг үзүүлсэн байна.

9-р сард IPO гаргах болон нэмж хувьцаа гаргах замаар гурван компани хөрөнгийн захаас санхүүжилт татжээ. Хамгийн сүүлд энэ оны 1-р сард хөрөнгийн захад 23 орчим тэрбум төгрөгийн арилжаа явагдаж байсан юм. Тухайн үед нийт арилжааны 88.3 хувийг нь ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа бүрдүүлж байжээ. Харин 9-р сарын нийт арилжааны 98.5 хувийг хувьцааны арилжаа дангаараа бүрдүүлсэн нь онцлог болж байна.

Хувьцааны анхдагч зах зээл төдийгүй хоёрдогч зах зээлд “Хай Би Ойл”, “Мах импэкс” зэрэг компаниудын хувьцаа их хэмжээгээр арилжсан нь хувьцааны арилжааны дүнд гол жинг дарсан байна. Тодруулбал, нэг өдрийн дотор “Мах импэкс” компанийн 11 хувь нь нэг тэрбум төгрөгөөр арилжжээ. Харин МҮЦБ-д 9-р сард “Анд энерги” компанийн нийт 5.3 сая төгрөгийн хувьцаа арилжсан байна. “Анд энерги” компанийн мэдээлснээр борлуулалтын орлогын төлөвлөгөөнөөс бага зэрэг хоцорч байгаа юм байна. Улаанбаатар хотод салбараа нээгээд байгаа тус компанийн хувьд он дуусахад зорилтгоо хүрэх төлөвтэй байгааг мэдээлж байсан юм. Мөн “Анд энерги” компанийн ТУЗ-ийн гишүүн, үүсгэн байгуулагч Д.Мөнхбаяр хувьцаа эзэмшигчдэдээ 2018 оны ашгаас ногдол ашиг тараахыг дэмжиж байгаагаа илэрхийлсэн. Гэхдээ шийдвэр ТУЗ-ийн хурлаар гарах хүлээлттэй байгаа юм.

Хувьцааны арилжаа идэвхжсэн 9-р сард гол индексүүд болон компаниудын хувьцааны ханш хэр хэлбэлзлийг харвал 5-р сараас хойш “Топ 20” индекс 20 мянган нэгжээс доогуур тогтож байв. Харин 9-р сард “Топ 20” индекс 2.4 орчим хувиар өсөхөд индекс бүртгэлтэй, зах зээлийн үнэлгээгээр тэргүүлэгч компаниудын хувьцааны ханш өссөн нь гол нөлөөг үзүүлжээ. Тухайлбал, “Талх чихэр” компанийн хувьцааны ханш нэг сарын хугацаанд 9 хувиар, харин “Говь” компанийн хувьцааны ханш энэ хугацаанд 14 хувиар тус тус өссөн юм. Түүнчлэн I ангиллын компаниудыг нэгтгэн тооцдог MSE A индекс өссөн бол II ангиллын MSE B индекс унасан байна. 9-р сард Монголын Хөрөнгийн биржийн хувьцааны бүртгэлийн ангилалд хэд хэдэн өөрчлөлт орсон. Одоогоор “Ард даатгал”, “Мандал даатгал” компаниуд I ангилалд шинээр бүртгүүлж, “Би Ди Сек” компанийн ангилал ахиснаар I ангилалд 13 компани бүртгэлтэй болоод байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ХААБ: Угаасан цагаан үргэлж ноосны арилжаа өмнөх оны мөн үеэс 2.9 дахин өссөн

Хөдөө аж ахуйн биржид угаасан цагаан үргэлж ноосны үнэ оны эхний 9-р сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 2.5 дахин өсөж, кг тутам нь 5,530 төгрөгт хүрээд байна. Энэ нь өмнө нь байгаагүй дээд түвшин болж байна. Мөн хонины угаасан цагаан үргэлж ноосны арилжаа оны эхний есөн сард нийт 11.5 мянган тонн хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2.9 дахин өссөн үзүүлэлт болж байгаа юм. Өнгөрсөн 7-р сард Хөдөө аж ахуйн бирж угаасан ноосны 0.32 хувийн шимтгэлийг 15 хувиар нэмэгдүүлж, харин самнасан ноосныхыг 0.2 хувь болгож бууруулжээ. “Энэ нь үндэсний үйлдвэрүүдээ дэмжсэн шийдвэр” гэдгийг Хөдөө аж ахуйн биржийн Гүйцэтгэх захирал Х.Баатар онцоллоо.

2017 онд хонины ноосны үнэ ханш тогтвортой байсан бол энэ он гарсаар бүх төрлийн хонины ноосны үнэ өссөн байна. Дотоодын түүхий эдийн үнэ өссөн нь үйлдвэрлэлийн өртөг өсөхөд хүрч, бүтээгдэхүүний үнэ өсөхөд нөлөөлж байна гэж “Эковүүл” компани мэдээллээ. “Эковүүл” компани хонины ноосыг дотооддоо боловсруулж, барилгын дулаан тусгаарлах материал үйлдвэрлэж байна. Нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүнээ дотоодод борлуулахаас гадна экспорт хийж байгаа бөгөөд нийт борлуулалтын 27 хувийг экспорт бүрдүүлж байгаа ажээ. Мөн борлуулалт нь энэ онд өмнөх оны мөн үеэс 7 хувиар өссөн талаар “Эковүүл” мэдээллээ. Цаашид АНУ болон Европт экспорт хийхээр зорин ажиллаж байгаа юм байна.

Түүнчлэн энэ салбарт үйл ажиллагаа явуулдаг Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Стандарт” ноос компани техник, технологийн шинэчлэл хийж байгаа талаар мэдээллээ. Тус компани 2019 оны III улиралд ноос угаах шинэ үйлдвэр ашиглалтад оруулах юм байна. Цаашид дотоодын зах зээлд эзлэх хувь хэмжээгээ нэмэгдүүлбэл, үйл ажиллагаагаа өргөжүүлж, экспорт хийх талаараа мэдээлсэн юм.

Эх сурвалж: BloombergTv.mn



Үр тариа хураалт 22.1 хувьтай байна

10 дугаар сарын 1-ний байдлаар нийтдээ 75.3 мянган га-гаас 107.6 мянган тонн үр тариа авч ургац хураалт 22.1 хувьтай байгаа талаар ХХААХҮЯ-наас мэдээллээ.

Мөн 10.5 мянган га-гаас 125.7 мянган тонн төмс, 6.0 мянган га-гаас 67.7 мянган тонн хүнсний ногоо хураан авснаар төмс, хүнсний ногооны хураалт 81.1-73.0 хувийн явцтай байна. Цаг агаарын нөхцөл байдлын улмаас чийг ихтэй буудай буух магадлал өндөр, цаашид ургацын чанар муудаж стандартын шаардлага хангахгүй нөхцөл байдал үүсч болзошгүй байгаа бөгөөд тариалангийн бүх бүс нутгуудаар өнгөрсөн 9-р сарын 27-ноос эхлэн усархаг бороо, уулаараа нойтон цас орж байгаа тул ургац хураалтын ажил түр зогсоод байна. Цаг агаарын хүндрэлийн улмаас орон нутагт үүсээд буй зарим тулгамдсан асуудлыг ажлын хэсэг томилон ажиллуулах замаар шуурхай шийдвэрлэж байна. Ургацыг малаас хамгаалах, хураалтын ажилд оюутан сурагчдыг татан оролцуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах зэрэг хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тусгасан ХХААХҮ-ийн сайдын албан тоотыг орон нутагт хүргүүлж хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Эх сурвалж: Montsame.mn

Төв банкнуудын алт худалдан авалт сүүлийн 3 жилийн оргилд хүрчээ

Төв банкнуудын алт худалдан авалт сүүлийн гурван жилийн дээд түвшинд хүрээд байгааг “World Gold Council”-ийн шинэ тайланд онцолсон байна. Оны эхний хагас жилийн байдлаар Төв банкнуудын алт худалдан авалт өнгөрсөн оны мөн үеэс найман хувиар өсөж, 193 тоннд хүрчээ.

ОХУ, Турк, Казахстан болон хөгжиж буй орнуудад энэ хандлага илүүтэй ажиглагдаж, нийт худалдан авалтын 86 хувийг бүрдүүлжээ. Олон Улсын Валютын Сангийн тайлангаас харахад энэ онд Египет улс 1978 оноос хойш анх удаа алт худалдаж авсан бол Энэтхэг, Индонез, Тайланд, Филиппин улс урт хугацааны дараа алтны зах зээлд эргэн орсон байна. Ийнхүү алтны эрэлт нэмэгдсэн нь ам.долларын нөлөөллийг багасгах зорилттой холбоотой гэж шинжээчид тайлбарлаж байна.

Эдийн засгийн хүндрэл, улс төрийн тогтворгүй байдлын үед алт хадгалах нь аюулгүйд тооцогддог. Мөн олон улсын нийт өрийн хэмжээ өссөөр байгаа тул Төв банкнууд алтны нөөцөө нэмэх сонирхол өсөж байна гэж “Forbes”-ийн судалгаанд дүгнэжээ.

Дэлхийн алтны зөвлөлийн тайланд тусгаснаар хамгийн их алтны нөөцтэй Төв банкны жагсаалтыг Холбооны Нөөцийн банк тэргүүлж байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар АНУ-ын Төв банкны алтны нөөц 8133 тонноор хэмжигдэж байсан. Энэ нь нийт гадаад валютын нөөцийнх нь 75 гаруй хувийг бүрдүүлж байна. Харин хоёрдугаарт бичигдэж байгаа Германы Төв банкны нөөц 3,370 тонн, удаах Франц улсын нөөц 2,450 тонн байна. Өөрөөр хэлбэл Холбооны Нөөцийн банкны алтны нөөц удаах байруудад бичигдэж байгаа гурван банкны алтны нийт нөөцөөс өндөр байгаа юм.

Сонирхолтой нь 2000 оноос хойш АНУ-ын алтны нөөц 8,100-8,150 тонны хооронд тогтвортой хадгалагдсан байна. Харин стратегийн гол өрсөлдөгчид гэгддэг БНХАУ, ОХУ нөөцөө ойролцоогоор тав дахин нэмэгдүүлжээ.

Харин Монгол Улсын хувьд оны эхний есөн сард нийт 14.3 тонн алт худалдаж авсан гэж Төв банк мэдээллээ. Энэ онд 22 тонн алт худалдан авах зорилго тавьсан нь өнгөрсөн оноос 10 хувиар өсгөсөн дүн юм. Төв банк 2017 онд анх удаа 20 тонн алт худалдаж авсан нь гадаад валютын албан нөөцийг 700 сая ам.доллараар нэмэгдүүлсэн байдаг.

Монголбанкны гадаад валютын албан нөөцийн 475 сая ам.долларыг буюу 17 хувийг мөнгөжсөн алт бүрдүүлсэн талаар Төв банк мэдээлсэн. Энэ онд нөөцийг зөвхөн алт тушаалтаас 700-800 сая ам.доллараар нэмэгдүүлэх зорилт тавьжээ.

“Алт-2” хөтөлбөрийн хүрээнд дотоодын алтны үйлдвэрлэлийг жил бүр 2-3 тонноор нэмэгдүүлж, 2020 он гэхэд 25 тоннд хүргэх зорилго тавиад байгаа аж. Мөн хөтөлбөрийн эрэл хайгуулын ажлын хүрээнд Монгол Улсын алтны нөөцөө 100-150 тонноор нэмэгдүүлнэ гэж Засгийн газар мэдээлж байгаа юм. Дотоодын алт үйлдвэрлэл 2017 оны жилийн эцсийн дүнгээр 19.8 тонн хүрсэн бол энэ оны 8-р сарын байдлаар 11.9 тонн хүрсэн гэж Үндэсний статистикийн хороо мэдээллээ.

Алтны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор 2014 онд алтны нөөц ашигласны татварыг борлуулалтын орлогоос 2.5 хувиар тооцох шийдвэр гарснаас хойш алт тушаалт эрчимтэй нэмэгдсэн гэж Төв банкны статистикаас харж болохоор байна. Татварын хөнгөлөлтийн хугацааг 2019 оноос цааш сунгах шаардлагатайг Төв банк илэрхийлж байсан юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

2019 оны төсвийн орлогын 27 хувийг уул уурхайгаас бүрдүүлэхээр тооцжээ

2019 онд уул уурхайгаас олох орлого 2018 оны батлагдсан түвшнээс 1.3 их наяд төгрөгөөр нэмэгдэж, гурван их наяд төгрөгт хүрнэ гэж төсвийн төсөлд тусгасан байна. Энэ нь төсвийн нийт орлогын 27 хувийг бүрдүүлэхээр байгаа нь 2017 оны батлагдсан түвшнээс таван нэгж хувиар өндөр үзүүлэлт болж байна. 8-р сарын байдлаар төсвийн орлогын 26 хувийг уул уурхайн салбар бүрдүүлсэн гэж Сангийн яам мэдээлсэн юм. Ирэх онд уул уурхайгаас олох орлогын 86 хувийг зөвхөн зэс, нүүрснээс бүрдүүлэхээр төлөвлөжээ. Тодруулбал, 42 сая тонн нүүрс экспортолж, 1.3 их наяд төгрөг, 1.4 сая тонн зэсийн баяжмал экспортолж, 1.3 их наяд төгрөг төсөвт төвлөрүүлэхээр тооцсон байна. Энэ жил нүүрсний экспортын хэмжээ эрс нэмэгдсэн хандлага ирэх онд үргэлжилнэ гэж Сангийн яам үзэж байна. Нүүрсний үнийг тонн тутмыг 75.9 ам.доллар, харин зэсийн хувьд тонн тутмыг нь 6,272 ам.доллараар тооцож төсөөллийг гаргажээ. Энэ оны төсвийн орлогыг 2018 оны батлагдсан түвшнээс 2.4 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж тооцсон байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

СЯ: Гадаадын зээл тусламжийн 78 хувийг хөрөнгө оруулалтад зарцуулна

2019 оны төсөвт 1.3 их наяд төгрөгийн гадаадын зээл тусламж авч ашиглахаар тооцсон байна. Үүнээс 38.5 хувь буюу 581 тэрбум төгрөгийг Азийн Хөгжлийн банкнаас авахаар байна. Харин 24 хувийг БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл эзэлж байгаа юм. Нийт гадаадын зээл тусламжийн 78 хувийг хөрөнгө оруулалтын зардалд зарцуулна гэж Сангийн яам мэдээллээ. Ирэх оны төсвийн алдагдал 1.9 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 5.4 хувьтай тэнцэж байна. Төсвийн алдагдлын дийлэнх хувийг гадаадын бага хүүтэй зээл тусламжаар санхүүжүүлнэ гэж Сангийн сайд мэдээллээ. Зарцуулалтын хувьд ирэх онд ашиглах гадаадын зээл тусламжийн 21 хувийг байгаль орчныг хамгаалах, цэвэрлэх байгууламж барих, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ашиглана. Харин 39 хувийг эрчим хүчний байгууламжийн бүтээн байгуулалт, нефтийн үйлдвэр зэрэгт ашиглахаар тооцжээ.

Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн АНУ-д хийсэн айлчлалын үеэр Мянганы сорилтын сангийн хоёрдугаар компакт гэрээ эцэслэгдэж, 350 сая ам.долларын буцалтгүй тусламж орж ирэхээр болсон юм. Мөн ОХУ-аас 100 тэрбум рублийн хөнгөлөлттэй зээл авч Дулааны III цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийг эхлүүлэх ажил судалгааны шатандаа явж байгааг Эрчим хүчний яам мэдээллээ.

Түүнчлэн БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр төв цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийг хийхээр төлөвлөсөн юм. Ирэх онд гадаадын хөнгөлөлттэй зээлийн 111 эх үүсвэрийн хөрөнгөөр 91 төсөл, тусламжийн эх үүсвэрийн хөрөнгөөр 41 төслийг санхүүжүүлэхээр тооцож байгаа юм байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

Дэлхийн банк: Монгол Улсын эдийн засаг 2018 онд 5.9 хувиар өсөх төлөвтэй

Дэлхийн банк Монгол Улсын энэ оны эдийн засгийн өсөлтийн төлөвийг 5.9 хувь болгож нэмэгдүүллээ. Ийнхүү өсөлтийн төлөвийг дээшлүүлэхэд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт болон гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна.

Түүнчлэн бизнесийн итгэл сэргэсэн нь голлон нөлөөлжээ. Цаашид хувийн секторын хэрэглээ, бизнесийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, өрхийн орлого өсөх төлөвтэй гэж дүгнэсэн байна. Хэдий тийм боловч улс төрийн болон гадаад хүчин зүйлийн эрсдэл өндөр хэвээр байгааг онцоллоо.

Хэдийгээр Зүүн Ази, Номхон далайн бүсийн хэмжээнд гадаад нөхцөл байдал харьцангуй тааламжгүй болж байгаа ч эдийн засгийн төлөв эерэг хэвээр байна гэж дүгнэсэн байна. Бүс нутгийн хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт энэ 6.3 хувь болж өмнөх оноос бага зэрэг буурна гэж тооцжээ. Үүнийг БНХАУ-ын эдийн засгийн тэнцвэр, зүй тогтол өөрчлөгдөж байгаатай холбон тайлбарлалаа.

Өнгөрсөн долоо хоногт Азийн Хөгжлийн банкны танилцуулсан тайланд тусгаснаар Монгол Улсын эдийн засаг 2018 онд 6.4 хувь, 2019 онд 6.1 хувиар өсөхөөр байгаа юм. Орон нутагт зуны эхэн саруудад гантай байснаас мал аж ахуйн үйлдвэрлэл доголдсон нь хөдөө аж ахуйн салбарын эдийн засагт эзлэх хувь хэмжээ 0.5 нэгж болон буурсан байна. Үүнийг эс тооцвол нүүрсний экспорт өссөнөөр уул уурхайн салбар эрчимжиж, хөрөнгө оруулалт нэмэгдсэн эерэг үзүүлэлт гарсныг онцолж байжээ.

Харин Олон Улсын Валютын Сангийн тэргүүн Кристин Лагард "Монгол Улс гадаад болон дотоод "шок"-уудад мэдрэг байгаа тул хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, төсвийн алдагдлыг бууруулах шаардлагатай" гэж байсан юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

2019 онд Төсвийн хөрөнгө оруулалтыг энэ оны батлагдсан түвшнээс 2 дахин нэмэхээр тооцжээ

2019 оны Төсвийн тухай хуулийн төсөлд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн дүнг 1.2 их наяд гаруй төгрөг байхаар төлөвлөсөн байна. Энэ нь 2018 оны батлагдсан түвшнээс хоёр дахин их дүн болж байна. Мөн ирэх оны төсвийн хөрөнгө оруулалтаар 117 сургууль, 143 цэцэрлэгийн барилгын ажил, 62 анхан шатлалын эмнэлгийн өргөтгөл, 34 сургуулийн дотуур байр зэрэг хатуу дэд бүтцийг санхүүжүүлэх юм байна. Мөн барих шилжүүлэх нөхцөлтэй концессын гэрээ шинээр байгуулахгүй гэж онцолжээ. Төсвийн хөрөнгө оруулалтад төлөвлөгөөгүй төслийг багтаахгүй байх шаардлагатайг УИХ-ын зарим гишүүд анхааруулж байгаа юм. Мөн сөрөг хүчний зүгээс хөгжлийн гол баримт бичгүүдийн зорилттой уялдуулж төсвийн хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх шаардлагатай гэсэн байр суурийг илэрхийллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.